



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 02

Хөх бүрд

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг  
зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам  
батлах тухай

Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 107 тоот тогтоолын хавсралт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйл 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нэгдүгээр Хуралдаанаас ТОГТООХ нь:

- 1.Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг 4 бүлэг, 18 заалттайгаар хавсралтаар баталсугай.
- 2.Салбар зөвлөлийн ажиллах журмыг гишүүдэд танилцуулж, мэдээллээр хангаж ажиллахыг нарийн бичгийн дарга (Д.Батбаатар)-т хариуцуулсугай.
- 3.Ажиллах журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хариуцлагатай ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР

648820007